

**“ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ,  
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ” АЙМГИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2026 он 1-р улирал

Сайншанд

Д/д Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
<b>1. Хүний нөөцийн цогц механизмыг төлөвшүүлэх</b>					
1	1.1. Хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга зүй, удирдлагаар хангах	2026	-	Улсын бүртгэлийн хэлтэс нь 2026 онд төрийн албан хаагчийг чадавхижуулах сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
2	1.2. Хүний нөөцийн удирдлагад мэдээллийн технологийг нэвтрүүлж төрийн албан хаагчдын Бүртгэл, хөдөлгөөний тайланг үнэн зөв гаргадаг болох	2026	-	Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд 2026 оны 02 сард байгууллагын хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөний тайланг гарган хүргүүлж ажилласан. Мөн 2026 оны 03 сарын 30-ны өдөр төрийн захиргааны албан тушаалын мэргэжлийн индексийн болон төрийн албан хаагчийн мэргэжил боловсролын судалгааг шинэчлэн гаргаж хүргүүлсэн. ХНУМТ системд албан хаагчдын мэдээллийн баяжилт өөрчлөлтийг тухай бүр хийж, сар бүр тайланг салбар зөвлөлд хүргүүлж ажилласан.	
<b>4. Албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, шатлан дэвших зарчмыг хэрэгжүүлэх</b>					

3	4.1. Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээнд үндэслэн албан хаагчдыг сургаж, ажлын байран дээр тасралтгүй хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх	2026	<p>Улсын бүртгэлийн хэлтэс нь албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон 2026 оны Сургалтын төлөвлөгөөг гарган батлаж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.</p> <p>Тус хэлтэс нь 2026 онд албан хаагчдын мэдлэг, боловсрол, харилцаа хандлагыг сайжруулахад онцгой анхаарч, ажлын байран дээр тасралтгүй хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор 7 хоног бүрийн лхагва гарагт “Өглөөний уулзалт- сургалт”-ыг зохион байгуулж хэвшээд байна.</p> <p>Тус “Уулзалт-сургалт”-ыг 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн зохион байгуулж “Төрийн албан хаагчийн ёс зүй болон хүний эрхийн мэдрэмжтэй байх, “Авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Архив, албан хэрэг хөтлөлт болон албан бичиг боловсруулалт”, “Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт”, “Эрүүл мэндийн даатгал”-ын асуудлаар, Байгууллагын өмч, түүний ашиглалт, хамгаалалт, зарцуулалт, данснаас хасах асуудлаар, “Байгууллага дахь эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа, хүүхэд хамгааллын бодлого” “Нийгмийн даатгалын тухай хууль”-д орсон өөрчлөлт, нийгмийн даатгалын төрөл, цахим үйлчилгээ, “Хувь хүний хөгжил, зорилго тодорхойлох, амьдралын тойрог 8x8x8”, “25x5” дүрэм”, “Эрүүл ажлын байрнаас эрүүл ажилтан” сэдэвт сургалтуудыг тус тус хийж, чөлөөт ярилцлага зохион байгуулсан нь албан хаагчдад мэдлэг, мэдээлэл олгосон үр дүнтэй уулзалт- сургалтууд болсон.</p> <p>Улсын бүртгэлийн хэлтэс нь “Албан хаагчдын нэгдсэн сургалт зөвлөгөөн”-ийг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Энэ удаагийн сургалт</p>
---	---	------	---

	<p>зөвлөгөөнийг шинэлэг байдлаар албан хаагчдыг мэдлэг, мэдээллээр хангах чадамжийг дээшлүүлэх, хувь хүний харилцаа хандлагад чиглэсэн албан хаагч нэг бүрийн оролцоог хангасан хэлбэртэй зохион байгуулж, Дэлхийн технологийн салбарын Шилдэг 100 илтгэгчийн нэг Н.Энхсайханыг урьж “Хиймэл оюун ухаан оновчтой хэрэглээ”, Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Б.Сэмжидтуяа “Өөрөөс эхлэх манлайлал”, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Дорноговь аймаг дахь референт Т.Мөнгөнчулуун оролцож албан хаагчдад “Жендэр ба хөдөлмөрийн хүрээний эрх” сэдвээр тус тус мэдээлэл хийж албан хаагчидтай чөлөөтэй харилцан ярилцаж, мэдээлэл солилцсон нь албан хаагчдыг ажлын байран дээр тасралтгүй хөгжүүлэхэд чухал үр дүнтэй сургалт болсон.</p>			<p>Улсын бүртгэлийн хэлтэс нь 2026 оныг албан хаагчдыг чадавхжуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх жил болгон зорилт тавин ажиллаж, тус зорилтын хүрээнд улсын бүртгэгч нарыг өөр бүртгэлийн чиглэлээр ажиллах мэдлэг, чадвартай болгох зорилгоор 2025 онд Сумдын бүртгэгч нарт хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийн бүртгэл хөтлөх эрх нээлгэж, 2026 оны 1 дүгээр улиралд Айраг сумын улсын бүртгэгч Б.Уранчимэг, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Номин-Эрдэнэ нарт Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх, Замын-Үүд сумын улсын бүртгэгч Д.Цэцэгсүрэн, Айраг сумын улсын бүртгэгч Б.Уранчимэг нарт Эд хөрөнгийн эрхийн бүртгэл хөтлөх эрхийг тус тус нээлгэн ажлын ачааллыг тэнцвэржүүлэн, туршлага судлуулан, чадавхжуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p>
4	<p>4.2. Нэг ажлын байранд 10 ба түүнээс дээш жил ажилласан албан хаагчдыг сэлгэн болон шилжүүлэн ажиллуулж ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, туршлага судлуулах тогтолцоог бүрдүүлэх</p>	-	2026	<p>Улсын бүртгэлийн хэлтэс нь Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд Энержи прагон ХХК-тай уулзалт</p>
<p><b>5. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн баталгаагаар хангах тогтолцоог төлөвшүүлэх</b></p>				
		-	2026	

5	5.2. Суманд ажиллах шинэ, залуу төрийн захиргааны албан хаагчдыг орон сууцаар хангах бодлого хэрэгжүүлэх		хийн тус хэлтсийн албан хаагчдад хөнгөлөлттэй үнээр байр захиалах мөн аймгийн Засаг дарга Г.Марттай уулзалт зохион байгуулж албан хаагчдыг түрээсийн орон сууцанд хамруулах талаар санал бодлоо солилцож, тус тус санал хүргүүлж ажилласан. Үр дүнд 2026 оны 1 дүгээр улиралд Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Б.Номин-Эрдэнэ хөнгөлттэй үнээр шинэ орон сууцанд орж, амьдрах нөхцөлөө сайжруулсан байна. Тус хэлтэс нь Суманд ажиллаж буй албан хаагчдын ажиллаж амьдрах нөхцөл боломжийг дээшлүүлэх нийгмийн баталгааг хангах зорилгоор Эрдэнэ сумын ЗДТГ-ртай хамтран ажиллаж, улсын бүртгэгч Ч. Энхжаргалыг төрийн албан хаагчийн түрээсийн орон сууцанд хамруулж амьдрах нөхцөлийг сайжруулан ажилласан.
6	5.3. Суманд тасралтгүй 5 жил ажилласан төрийн захиргааны албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн урамшууллаар тооцон 5 жил тутам олгох [2023 оноос эхлэн болзол хангасан албан хаагчдад олгоно/	2026	Тус хэлтсээс 2026 онд Суманд тасралтгүй ажилласан төрийн захиргааны албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн урамшуулал авах албан хаагч байхгүй болно.
7	5.4. Ажилтан, албан хаагчдын ажлын байрыг орчин үеийн оффисын стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	2026	"Байгууллагын үйлчилгээний - стандарт"-ын хэрэгжилтэд анхаарч тус хэлтэс нь ажлын байрны нөхцөлийг сайжруулах, албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, үйлчлүүлэгчдийн ая тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор байршлаа сольж 2025 оны 12 сард Саруул талын өргөө ХХК-ийн шинэ барилгад шилжин орж үйл ажиллагаа явуулж байна.

					<p>Албан хаагчид үйлчилгээний стандарт шаардлагад нийцсэн хувцаслалтаар жигдрэх ажлыг зохион байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Албан хаагчдын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажилтны амралтын өрөөг тохижуулан ажилласан.</p> <p>Хүүхдийн төлөө үндэсний үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол болон бусад хүүхдийн эрхийг хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Хүүхдийн өрөө"-г тохижуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний зааланд болон улсын бүртгэгч нарын ширээн дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээ, сонголын бэрхшээлтэй иргэнд зориулсан таних тэмдэг 9-ыг мөн "Тусламжийн хонх"-ыг байршуулан стандартад нийцүүлэн тохижуулж ажилласан.</p>
8		5.5. Ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээгээр нэмэгдэл хөлс, урамшуулал олгох журам баталж хэрэгжүүлэх	2026		<p>Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 3.1-т заасан явцын ярилцлагыг хийж, 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2.2-г Төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид олгоно" гэж зааснаар батлагдсан цалингийн санд багтаан гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийг 1</p>

				<p>дүгээр улирлын байдлаар дүгнэж, мөнгөн урамшуулал олгож ажиллана уу гэсэн УБЕГ-ын Үнэлгээний багийн ирүүлсэн чиглэлийн дагуу хэлтсийн албан хаагчдын 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн тайланг Үнэлгээний баг үнэлж дүгнэсэн. Журамд заасны дагуу 85-аас дээш үнэлэгдсэн 24 албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгон ажилласан.</p>



ТАЙЛАН ГАРГАСАН:  
 ЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ..... С.ЭРДЭНЭХИШИГ